ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 17 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/148/НА/СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2022 он | *Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,*<br>*Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*<br>*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*<br>*Аудитын менежер: И.Сэмжидмаа*<br>*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*<br>*Ахлах аудитор: Д.Нармандах*<br>*Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn*<br>*Аудитор: А.Даваасүрэн*<br>*Утас: 70003775,*<br>*Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com* |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8

3. Аудитын тайлан....9

3.1 Ерөнхий зүйл....9

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....9

3.4 Материаллаг байдал ....10

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....10

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....10

3.6.1 Төсвийн төлөвлөлт ....10

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....11

3.8 Аудитын гол асуудал ....11

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....11

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....11

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....12

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....12

4. Аудитын илрүүлэлт ....**Error! Bookmark not defined.**

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....**Error! Bookmark not defined.**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГ | Засгийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

,

## 1. Аудитын санал дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 237

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН 17 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.СОЛОНГО ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 17 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 17 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020150

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **21,172,454.25** | **21,686,717.25** |
| **33** | **АВЛАГА** | 1,340,527.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,340,527.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 19,831,927.25 | 21,686,717.25 |
| **354** | **Хангамжийн материал** | 19,831,927.25 | 21,686,717.25 |
| 35460 | Хүнсний материал | 748,110.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,083,817.25 | 21,686,717.25 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,348,770,776.09** | **1,319,450,978.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,348,770,776.09 | 1,319,450,978.33 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,348,262,026.06 | 1,318,997,228.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,290,000,000.00 | 1,290,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (16,125,000.03) | (37,625,000.07) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 23,904,106.00 | 23,904,106.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (895,086.00) | (3,047,684.04) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,871,533.78 | 24,871,533.78 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,945,905.66) | (5,225,928.18) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 28,793,763.00 | 28,793,763.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (341,385.03) | (2,673,562.23) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 508,750.03 | 453,750.07 |
| 39301 | Программ хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (41,249.97) | (96,249.93) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,369,943,230.34** | **1,341,137,695.58** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,340,527.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,340,527.00 | 0.00 |
| **413** | **Өглөг** | 1,340,527.00 | 0.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,340,527.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,368,602,703.34** | **1,341,137,695.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,368,602,703.34 | 1,341,137,695.58 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,368,602,703.34 | 1,341,137,695.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,338,092,082.28 | 1,367,262,176.34 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 30,510,621.06 | (26,124,480.76) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,369,943,230.34** | **1,341,137,695.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **355,627,437.75** | **359,183,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,764,837.75** | **1,340,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 46,764,837.75 | 1,340,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 46,764,837.75 | 1,340,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 46,764,837.75 | 1,340,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **308,862,600.00** | **357,843,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 295,082,000.00 | 342,405,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 295,082,000.00 | 342,405,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 175,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 175,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 13,605,600.00 | 15,438,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,605,600.00 | 15,438,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **325,116,816.69** | **385,308,280.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **325,116,816.69** | **385,308,280.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 314,622,936.07 | 365,098,694.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 232,208,248.12 | 263,153,503.69 |
| 210101 | Үндсэн цалин | 189,765,910.12 | 209,202,492.71 |
| 210102 | Нэмэгдэл | 27,928,463.72 | 32,529,133.86 |
| 210104 | Урамшуулал | 14,513,874.28 | 21,421,877.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,781,077.54 | 28,321,278.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,143,698.57 | 17,160,826.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,406,199.10 | 2,594,398.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,125,199.80 | 2,322,739.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 281,399.20 | 690,184.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,824,580.87 | 5,553,130.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,022,680.72 | 14,939,782.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,833,656.61 | 4,605,209.93 |
| 210302 | Түлш, халаалт | 5,161,094.11 | 6,737,107.39 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,027,930.00 | 3,597,465.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,385,620.00 | 3,845,720.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 483,380.00 | 698,310.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 200,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 146,300.00 | 143,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 23,000.00 | 123,261.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 532,940.00 | 2,880,749.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 20,550,883.00 | 24,611,551.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 106,600.00 | 1,634,651.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,444,283.00 | 22,976,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 75,800.00 | 542,660.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,800.00 | 542,660.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,598,626.69 | 29,684,197.76 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 114,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,348,626.69 | 29,319,797.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,493,880.62 | 20,209,586.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 70,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 70,000.00 | 300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,582,919.28 | 17.68 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,582,919.28 | 17.68 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,840,961.34 | 19,909,568.77 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,840,961.34 | 19,909,568.77 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **30,510,621.06** | **(26,124,480.76)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **30,510,621.06** | **(26,124,480.76)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | - | - | 1,338,092,082.28 | 1,338,092,082.28 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **-** | **-** | **1,338,092,082.28** | 1,338,092,082.28 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 30,510,621.06 | 30,510,621.06 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **-** | **-** | **1,368,602,703.34** | 1,368,602,703.34 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **-** | **-** | **1,368,602,703.34** | 1,368,602,703.34 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | (1,340,527.00) | (1,340,527.00) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | 1,367,262,176.34 | 1,367,262,176.34 |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **-** | **-** | **2,734,524,352.68** | 2,734,524,352.68 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(/төгрөгөөр/)*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **-** | **357,843,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **357,843,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 342,405,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 342,405,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 15,438,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 15,438,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **-** | **357,843,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **357,843,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **337,634,213.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 257,931,261.33 |
| 210101 | Үндсэн цалин | - | 203,980,250.35 |
| 210102 | Нэмэгдэл | - | 32,529,133.86 |
| 210104 | Урамшуулал | - | 21,421,877.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 34,884,048.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 23,723,595.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 2,594,398.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 2,322,739.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 690,184.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 5,553,130.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 14,939,782.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 4,605,209.93 |
| 210302 | Түлш, халаалт | - | 6,737,107.39 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 3,597,465.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 4,362,510.60 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 444,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 143,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 142,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,367,610.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 2,264,800.00 |
| **2105** | **Нормативд зардал** | - | 23,218,441.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | (59,749.00) |
| 210502 | Хоол, хүнс | - | 22,228,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,049,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 498,500.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 498,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 721,660.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 721,660.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 1,078,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 828,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **20,209,586.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 17.68 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 17.68 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 19,909,568.77 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 19,909,568.77 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 357,843,800.00 | 337,934,213.55 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 357,843,800.00 | 337,934,213.55 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 357,530,800.00 | 337,634,213.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 274,581,700.00 | 257,931,261.33 |
| 210101 | Үндсэн цалин | 221,687,600.00 | 203,980,250.35 |
| 210102 | Нэмэгдэл | 28,465,500.00 | 32,529,133.86 |
| 210104 | Урамшуулал | 24,428,600.00 | 21,421,877.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,196,500.00 | 34,884,048.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,213,100.00 | 23,723,595.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,746,000.00 | 2,594,398.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,196,900.00 | 2,322,739.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 549,100.00 | 690,184.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,491,400.00 | 5,553,130.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,939,800.00 | 14,939,782.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,593,600.00 | 4,605,209.93 |
| 210302 | Түлш, халаалт | 6,748,700.00 | 6,737,107.39 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,597,500.00 | 3,597,465.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,834,200.00 | 3,816,161.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 444,700.00 | 444,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 161,000.00 | 143,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 142,400.00 | 142,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 821,300.00 | 821,261.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,264,800.00 | 2,264,800.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 25,680,100.00 | 23,764,790.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 486,600.00 | 486,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,139,300.00 | 22,228,790.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,054,200.00 | 1,049,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 498,500.00 | 498,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 498,500.00 | 498,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 721,700.00 | 721,660.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 721,700.00 | 721,660.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,078,300.00 | 1,078,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 828,300.00 | 828,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 313,000.00 | 300,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 313,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 313,000.00 | 300,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 357,843,800.00 | 337,934,213.55 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 342,405,500.00 | 322,495,931.23 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 342,405,500.00 | 322,495,931.23 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 15,438,300.00 | 15,438,282.32 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 15,438,300.00 | 15,438,282.32 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэрлэн сумын 17 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэрлэн сумын 17 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл Бид багшийн ёс зүй харилцаа хандлага ур чадварыг сайжруулж, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүүхдийн оролцоонд тулгуурлан тэдний хөгжлийг дэмжин, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, эрүүл тав тухтай орчинд суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоотой ажиллана.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын 17 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 298,264.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,965.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,474.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 21,687.0 мянган төгрөг болж 1,855.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,368,119.4 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,556.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 60,191.4 мянган төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 357,843.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 357,843.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 337,934.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 342,405.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 15,438.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 15,438.3 төгрөг, улсын төсвөөс 342,405.5 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 357,843.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 337,934.2 мянган төгрөг буюу 94.4 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 19,909.6 мянган төгрөг буюу 5.6 хувийн татан төвлөрүүлэн хийгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зарлага байхгүй байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хэрлэн сумын 17 дугаар Цэцэрлэг нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 орлогын 83,117.5 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлсэн.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 317,911.5 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,851.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,851.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Зөвлөмж

1. *Илрүүлэлт:* Тайлант онд 1,851.8 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын эр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хэрлэн сумын 17 дугаар цэцэрлэг | 2 | 1.8 | - | - | - | - | 1 | - | 1 | 1.8 |